

“Инженер, технологийн дээд боловсрол төсөл”-ийн хүрээнд Япон Улсад дараах хөтөлбөрүүдэд суралцахад тавигдах шаардлага

Төслийн товч танилцуулга

Монгол Улс, Япон Улсын хоорондох стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд иенийн хөнгөлөлттэй зээлээр “Инженер, технологийн дээд боловсрол” төслийг 2014 оноос эхлэн хэрэгжүүлж байна.

Төслийн хэрэгжих хугацаанд МУИС болон ШУТИС –ийн багш судлаач, оюутан нийт 1000 хүнийг Японы их сургууль болон Японы Үндэсний Технологийн Коллежид суралцуулахаар төлөвлөсөн.

1. Коосэн сургалтын хөтөлбөр (Хугацаа: Элсэлт жил бүрийн 4 дүгээр сараас эхлэн 7 дугаар сарыг дуустал үргэлжилнэ)

Суралцах хугацаа	Дипломын боловсрол /200 хүн/	Монголд 1,5 жил + Японд 3 жилийн хугацаатай сургалт
Шалгуур үзүүлэлт	<p>Суралцагчдад тавигдах шаардлагыг бүрэн хангаж, сонгон шалгаруулалтад тэнцсэн оюутан ШУТИС-д хичээллэх 1,5 жилийн хугацаатай Япон хэлний бэлтгэл сургалтын хөтөлбөрт элсэн суралцана. Тус сургалтын кредитийн үнэлгээ нь ШУТИС-ийн кредитийн үнэлгээтэй ижил байх ба Монголд суралцах хугацааны сургалтын төлбөрийг оюутан өөрөө хариуцна.</p> <p>Бэлтгэл Коосэн сургалтын хөтөлбөрт амжилттай суралцан Японд суралцах шалгалтад /EJU/ тэнцсэн оюутан дараа оны 4 дүгээр сард тус төслийн санхүүжилтээр Японы Коосэн сургуулийн 3 дугаар дамжаанд шилжин суралцана. Япон Улсад нийт 3 жил суралцаж, бакалаврын өмнөх дээд боловсролын зэргийн дипломтой төгсөнө.</p> <p>Коосэн сургуулиа төгсөөд ажиллах хугацаандаа ШУТИС-тай байгуулсан гэрээний дагуу Коосэн сургалтын хөтөлбөрийн нэмэлт сургалтад хамрагдаж, бакалаврын боловсрол эзэмших боломжтой. Харин Японд суралцах шалгалтад /EJU/ тэнцээгүй оюутан кредит дүйцүүлэн ШУТИС-ийн 1 дүгээр дамжаанд элсэн суралцана.</p> <p>Тавигдах шаардлага:</p> <ol style="list-style-type: none">1. Монгол Улсын иргэн байх;2. Бүрэн дунд боловсрол эзэмшсэн байх;3. 22 нас хүртэл байх;	

4. Төсөл хэрэгжүүлэх нэгжээс зохион байгуулах урьдчилсан сорилд хамрагдаж нийт авах онооны 50-аас дээш хувийн амжилт үзүүлсэн байх, шалгалтын өдөр математик, физик, химийн хичээлээр улсын чанартай олимпиадад оролцсон бол 50 оноо авсанд тооцно.
5. Элсэлтийн ерөнхий шалгалтын математик, физикийн хичээлийн босго оноо 650, химийн хичээлээр шалгалт өгсөн бол давуу тал болно. Хэрэв инженер, технологийн чиглэлээр суралцаж байгаа бол суралцсан хугацааны сурлагын голч дүн 3.0 ба түүнээс дээш /Химийн шалгалтын оноог босго оноонд тооцохгүй/;
6. Техникийн авъяастай, инженер, технологийн чиглэлээр суралцах чин эрмэлзэлтэй, Коосэн сургуулийг төгсөөд эх орныхоо аж үйлдвэрийн салбарт шууд ажиллах хүсэлтэй байх;
7. Суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх гэрээ болон үг гэрээний хавсралт болох үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээний нөхцөлтэй танилцаж зөвшөөрсөн байх;
8. Элсэгч нь сүүлийн хоёр жилийн хугацаанд математик, физик, химийн чиглэлээр улсын болон олон улсын олимпиад, инженер, технологийн чиглэлээр уралдаан тэмцээнд оролцон амжилт гаргаж байсан бол давуу тал болно.

Сонгон шалгаруулалт болон суралцах үйл явц

1



Нэгдүгээр шатны шалгаруулалт:

Төсөл хэрэгжүүлэх нэгж нь ШУТИС – тай хамтран /жил бүрийн 4 дүгээр сард/ урьдчилсан

2



Хоёрдугаар шатны шалгаруулалт:

Урьдчилсан сорилын шалгуур хангасан элсэгчийг ЭЕШ-ийн босго онооны дарааллаар жагсаан

3



Шилжин суралцах:

ШУТИС-д 1,5 жил бэлтгэл хөтөлбөрт хамрагдаж суралцан болзол хангасан оюутан Японы 51 Коосэн сургуульд



Японы Коосэн сургуульд 3 жил

суралцаж Дипломын боловсрол эзэмшинэ. Төгсөж ирээд Монголд 5-аас доошгүй жил ажилласнаар уг зээл

сорилыг улсын
хэмжээнд зохион
байгуулна.

хяналтын тоонд
багтаан элсүүлнэ.

суралцах эрхтэй.
Япон Улсад суралцах
хугацаанд гарах
зардлыг зээл хэлбэрээр
олгоно.

нь тэтгэлэг болно.

Өөрийн хүсэлтээр
ШУТИС-д суралцан
бакалаврын зэрэг авч
болно.

Дэлгэрэнгүй мэдээлэл авах бол

- www.mjeed.edu.mn
- Утас: 315563

2. Бакалаврын хамтарсан хөтөлбөр (Хугацаа: Элсэлт жил бүрийн 4 дүгээр сараас эхэлнэ)

Суралцах хугацаа	Бакалаврын зэрэг /320 хүн/	Монголд 2,5 жил + Японд 2 жилийн хугацаатай сургалт
Шалгуур үзүүлэлт	<p>Суралцагчдад тавигдах шаардлагыг бүрэн хангаж, сонгон шалгаруулалтад тэнцсэн оюутан ШУТИС-д хичээллэх 2,5 жилийн хугацаатай бакалаврын хамтарсан хөтөлбөрт элсэн суралцана. Тус сургалтын кредитийн үнэлгээ нь ШУТИС-ийн кредитийн үнэлгээтэй ижил байх ба Монголд суралцах хугацааны сургалтын төлбөрийг оюутан өөрөө хариуцна.</p> <p>Бакалаврын хамтарсан хөтөлбөрт амжилттай суралцан Япон Улсад “Шилжин суралцах шалгалт”-д тэнцсэн оюутан суралцаж буй мэргэжлээрээ Японы их сургуульд 2 жил суралцах бөгөөд хоёр улсын их сургуулийн бакалаврын зэргийн хос дипломтой төгсөнө.</p> <p>Сонгон шалгаруулалтад оролцох суралцагчид доорх шалгуурууд тавигдана.</p> <ol style="list-style-type: none">1. Монгол Улсын иргэн байх;2. Бүрэн дунд боловсрол эзэмшсэн байх;3. 22 нас хүртэл байх;4. Төсөл хэрэгжүүлэх нэгжээс зохион байгуулсан урьдчилсан сорилд хамрагдаж нийт авах 100 онооны 50-иас дээш хувийн амжилт үзүүлсэн байх, шалгалтын өдөр улсын чанартай олимпиадад амжилттай оролцсон бол 50 оноо авсанд тооцно.	

5. Элсэлтийн ерөнхий шалгалтын /ЭЕШ/ математик, физикийн шалгалтын босго оноо 680, Хар зургийн шалгалт /зөвхөн архитектурын чиглэлээр элсэгчдэд хамаарна/ - ын босго оноо 650 ба түүнээс дээш байх; Хэрэв инженер, технологийн чиглэлээр суралцаж байгаа бол суралцсан хугацааны сурлагын голч дүн 3.0 ба түүнээс дээш;
6. Дээрх оюутныг тухайн сургууль нь хамтарсан сургалтын хөтөлбөрт суралцахыг дэмжсэн байх;
7. Инженер, технологийн чиглэлээр суралцах чин эрмэлзэлтэй, их сургуулиа төгсөөд эх орныхоо аж үйлдвэрийн салбарт ажиллах хүсэлтэй байх;
8. Суралцагчдад олгох “Боловсролын зээлийн сан”-гийн тавигдах нөхцөл, гэрээ, эргэн төлүүлэх гэрээ болон уг гэрээний хавсралт болох үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээний нөхцөлтэй танилцаж зөвшөөрсөн байх;

Сонгон шалгаруулалт болон суралцах үйл явц

1



Нэгдүгээр шатны шалгаруулалт:

Төсөл хэрэгжүүлэх нэгж нь ШУТИС – тай хамтран /жил бүрийн 4 дүгээр сард/ урьдчилсан сорилыг Монгол Улсын хэмжээнд зохион байгуулна.

2



Хоёрдугаар шатны шалгаруулалт:

Урьдчилсан сорилын шалгуур хангасан элсэгчийг ЭЕШ-ийн босго онооны дарааллаар жагсаан элсэлтийн хяналтын тоонд багтаан элсүүлнэ.

3



Шилжин суралцах: ШУТИС-д 2,5 жил хөтөлбөрт хамрагдаж, шилжин суралцах болзол хангасан оюутнууд Японы Консорциумын 10 их сургуульд суралцана. Япон Улсад суралцах хугацаанд гарах зардлыг зээл хэлбэрээр олгоно.



Японы их сургуульд 2 жил суралцаж төгссөнөөр ШУТИС болон Японы их сургуулийн бакалаврын хос дипломтой инженер болж төгсөнө.

Төгсөж ирээд Монголд 5-аас доошгүй жил ажилласнаар уг зээл

3. Магистрын сургалт (Хугацаа: Жил бүрийн 4 болон 10 дугаар сард)

<p>Суралцах хугацаа</p>	<p>Магистрын зэрэг /100 хүн/</p>	<p>2 жилийн хугацаатай сургалт /Япон Улсад/</p>
<p>Шалгуур үзүүлэлт</p>	<p>МУИС болон ШУТИС-ийн тэргүүлэх чиглэлийн судалгааны сэдвээр эрдэм шинжилгээ, судалгааны ажилд хамтран ажиллаж байгаа бөгөөд тус сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлагыг бүрэн хангаж, сонгон шалгаруулалтад тэнцсэн багш, судлаачид Япон Улсын их сургуулийн Магистрын сургалтын хөтөлбөрт хамрагдана.</p> <p>Магистрын сургалтын хөтөлбөрт элсэгчдэд тавигдах шаардлага:</p> <ol style="list-style-type: none"> 1. Монгол Улсын иргэн байх; 2. 35 нас хүртэл байх; 3. Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль болон гадаадын их, дээд сургуулийг инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр суралцаж төгссөн байх; 4. Бакалаврын дипломын голч дүн 2.8 аас дээш байх; 5. Гадаад хэлний шалгалт: Япон хэлний түвшин тогтоох JLPT шалгалтын N2 түвшин, эсвэл Англи хэлний TOEFL шалгалтын оноо PBT-500, IELTS шалгалтын оноо 5.0 ба түүнээс дээш байх; 6. Японы их сургуульд элсэн суралцах болзол хангаж, суралцах урилга хүлээн авсан байх; 7. Сургууль /ажлын газар/ нь магистрын хөтөлбөрт суралцахыг дэмжсэн байх; 8. Суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх гэрээ болон уг гэрээний хавсралт болох үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээний нөхцөлүүдийг хүлээн зөвшөөрсөн байх; 	

**Хамрах
хүрээ**

1. Инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр МУИС болон ШУТИС –д ажиллаж буй эрдэм шинжилгээний ажилтан, залуу багш нар;
2. МУИС болон ШУТИС-д хамтарсан судалгааны сэдвээр эрдэм шинжилгээ, судалгааны ажилд хамтран ажиллаж буй багш, судлаачид болон эрдэм шинжилгээний ажилтан;

Сонгон шалгаруулалт болон суралцах үйл явц

1



**Нэгдүгээр шатны
шалгаруулалт:**

Сургуулийн
ажлын хэсэг нэр
дэвшигчийг
тодруулна

2



**Хоёрдугаар шатны
шалгаруулалт:**

Төсөл хэрэгжүүлэх
нэгж, ажлын хэсэгтэй
хамтран бичиг
баримтын бүрдүүлэлт
болон ярилцлага
хийнэ

3



**Гуравдугаар шатны
шалгаруулалт:**

Төслийн удирдах
хороогоор хэлэлцэн
шийдвэрлэнэ



Шилжин суралцах:

Холбогдох салбарын
сайдын тушаалаар
баталгаажуулснаар
тухайн сургуульдаа
шилжин суралцана.

4. Докторын сургалт (Хугацаа: Жил бүрийн 4 болон 10 дугаар сард)

Суралцах хугацаа	Докторын зэрэг /60 хүн/	3 жилийн хугацаатай сургалт /Япон Улсад/
-----------------------------	--------------------------------	---

МУИС болон ШУТИС-ийн тэргүүлэх чиглэлийн судалгааны сэдвээр эрдэм шинжилгээ, судалгааны ажилд хамтран ажиллаж байгаа бөгөөд тус сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлагыг бүрэн хангаж, сонгон шалгаруулалтад тэнцсэн багш, судлаачид Япон Улсын их сургуулийн Докторын сургалтын хөтөлбөрт хамрагдана.

Магистрын сургалтын хөтөлбөрт элсэгчдэд тавигдах шаардлага:

1. Монгол Улсын иргэн байх;
2. 40 нас хүртэл байх;
3. Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль болон гадаадын их, дээд сургуулийг инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр суралцаж төгссөн байх;
4. Магистрын дипломын голч дүн 3.0-аас дээш байх;
5. Гадаад хэлний шалгалт: Япон хэлний түвшин тогтоох JLPT шалгалтын N2 түвшин, эсвэл Англи хэлний TOEFL шалгалтын оноо PBT-500, IELTS шалгалтын оноо 5.0 ба түүнээс дээш байх;
6. Японы их сургуулиудад элсэн суралцах болзол хангаж, суралцах урилга хүлээн авсан байх;
7. Сургууль /ажлын газар/ нь докторын хөтөлбөрт суралцахыг дэмжсэн байх;
8. Суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх гэрээ болон үг гэрээний хавсралт болох үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээний нөхцөлүүдийг хүлээн зөвшөөрсөн байх;

**Шалгуур
үзүүлэлт**

**Хамрах
хүрээ**

- ✓ Инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр МУИС болон ШУТИС –д ажиллаж буй эрдэм шинжилгээний ажилтан, залуу багш нар;
- ✓ МУИС болон ШУТИС-д хамтарсан судалгааны сэдвээр эрдэм шинжилгээ, судалгааны ажилд хамтран ажиллаж буй багш, судлаачид болон эрдэм шинжилгээний ажилтан;